

# Мэдээллийн самбар - 6.

## Мод боловсруулалт, ашиглалт



Эрт дээр үеэс хүмүүс модыг юунд ашиглаж ирсэн талаар та үүнээс өмнө бодож байсан уу? Мод байгаагүй бол хүмүүс түлэх түлээгүй, амьдрах орон гэргүй, ажлын багаж хэрэгсэлгүй байх байсан байх даа. Байшин барих байтугай гэрийн мод ч хийхэд хэцүү. Ингээд бодохоор амьдралыг модгүйгээр төсөөлөхийн аргагүй.

Тэгэхээр мод хангалттай байх нь бидэнд чухал байгаа биз. Тийм болохоор бид ойжуулалт хийж, ойг арчлан хамгаалдаг юм. Мод нь байгалийн нөхөн сэргээгддэг материал болохоор хүн төрөлхтөн оршин тогтнож байгаа түүхийн бүхий л хугацаандаа модыг ашиглаж иржээ. Бидний өвөг дээдэс модыг аль болох олон талаар ашиглахын тулд зөв боловсруулах арга барилд суралцжээ.

Модыг боловсруулж банз, модлог шахмал хавтан, цаас үйлдвэрлэдэг.

### Банз үйлдвэрлэх

- хөрөө рам болон туузан хөрөөн дээр бөөрөнхий модыг уртааш нь зүсэж банз үйлдвэрлэдэг
- зүссэн банзаа хатаалгын цех эсхүл наранд хатаана



Намайг гоёхон мод хэмээн магтах нь надад ихэд таатай байна!



### Банзны төрөл

- банз
- зүсмэл банз
- хагас зүсмэл банз
- жижиг банз

### Банз

Банзны өргөн нь зузаанаасаа 2 дахин илүү байдаг. Нэг үгээр хэлэхэд хавтгай хэлбэртэй гэсэн үг. Банзыг дараах байдлаар ангилна:

- банзны зузаан 40 мм-ээс их
- банзны зузаан хамгийн ихдээ 40 мм
- зах банз – зузаан нь хамгийн ихдээ 25 мм
- зах банзны – зузаан нь хамгийн ихдээ 25 мм бөгөөд зүүн талын зах банзыг уртааш нь хөрөөдсөн байх

### Зүсмэл банз

Зузаан нь өргөнөөсөө хоёр дахин их, тэгш өнцгөөр зүссэн.

- дүнз – хөндлөн огтлолын хэмжээс нь 100 см<sup>2</sup> их байх
- дүнзэнцэр – хөндлөн огтлолын хэмжээс нь 25 – 100 см<sup>2</sup>
- банз – хөндлөн огтлолын хэмжээс нь 10 см<sup>2</sup> бага байх

Хөрөө рам-д банз, дүнзэнээс гадна төмөр замын дэр мод, паркет болон хуулга үйлдвэрлэдэг.



Модны ашиг тус нь энд нэрлэснээр зогсохгүй...

- хүрээлэн буй орчинд ээлтэй нөхөн сэргээгддэг түүхий эдэд тооцогддог. Бусад үнэт түүхий эдийг бүрэн орлох чадвартай. Иймдээ ч модыг 21 зууны материал гэж үзэж байгаа билээ!
- манай гаригийн хүн нэг бүрд 1 м<sup>3</sup> залуу ой ноогдож байна.
- Гурван ам бүлтэй айлд 80 жилийн хугацаанд шинээр ургаж байгаа 240 м<sup>3</sup> шинэ ой оногдож байна. Үүний 140 м<sup>3</sup> модоор нь дулаалга сайтай байшин барьж 80 жилийн турш түлшинд хэрэглэнэ гэж бодоход үлдэж байгаа 100 м<sup>3</sup> модыг нь тавилга, хөгжмийн зэмсэг, чөлөөт цагаа өнгөрөөх бусад зүйлд хэрэглэх боломжтой юм.